

**АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ МОНГОЛ
УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

**A STUDY COMPARISON OF THE CRIMINAL LAW OF THE UNITED
STATES OF AMERICA WITH THE CRIMINAL LAW OF MONGOLIA**

И.Санчиргарав

*Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр Гүйцэтгэлийн албаны
сургуулийн Аюулгүй байдлын тэнхимийн багш, хууль зүйн магистр, хошууч*

Хураангуй: Америкийн нэгдсэн улсын эрүүгийн хууль, ялын бодлого, гэмт хэргийн ангилал, томъёолол, гэмт хэрэгт тавигдах шалгуур шинжүүд, ялын төрөл, хэмжээ зэргийг судалж мөн тодорхой нэг төрлийн гэмт хэргийг Монгол Улсын эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгтээ харьцуулж онцлог талуудыг тодорхойлж сайн жишиг, шийдлийг нээн илрүүлэхэд чиглэгдэнэ.

Түлхүүр үгс: Америкийн нэгдсэн улс, Монгол Улс, эрүүгийн хууль, гэмт хэрэг, ял, эрүүгийн хариуцлага, ялын бодлого

Abstract: By studying the criminal law and sentencing policy of the United States of America, the classification of crimes, formulas, the criteria for crimes, the type and amount of punishment, and comparing a specific type of crime with the crime specified in the criminal law of Mongolia, identifying the features and discovering good standards and solutions. Will be directed

Keywords: United States of America, Mongolia, criminal law, crime, win, criminal liability, sentencing policy.

Үндсэн хэсэг

Америкийн нэгдсэн улс нь холбооны улс учир тэнд 51 бие даасан эрх зүй үйлчилнэ, өөрөөр хэлбэл холбооны Эрүүгийн хууль тогтоомж болон 50 муж улсын Эрүүгийн хууль тогтоомж үйлчилдэг байна. АНУ-д шүүхийн прецедент (*хэвшүүлэн жишиг болгосон*) нь хууль тогтоомжийн нэгэн адил эрх зүйн эх сурвалж болно. 50 муж улсын хагас нь төрөлжүүлэн нэгтгэсэн Эрүүгийн хуультай бол зарим мужид Эрүүгийн хууль гэж байхгүй зэрэг нэлээд онцлогтой. Тухайлбал АНУ-ын 50 муж улсын 36 нь цаазаар авах ялыг хэрэглэдэг гэхээр 50 өөр улс шиг санагдаж болох юм.

АНУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн үндсэн эх сурвалж бол Үндсэн хууль бөгөөд хууль, хуульчилсан актууд Үндсэн хуульд яв цав нийцсэн байх ёстой. Ялангуяа Эрүүгийн хууль нь Үндсэн хуулийн хэм хэмжээг улам бэхжүүлж хамгаалдаг. Муж улс тус бүрдээ Эрүүгийн хуультай болохоор нэг буюу төсөөтэй гэмт хэргүүдэд өөр өөр төрлийн ял оноож байх жишээтэй.

Бие даасан хуультай болоход 1962 оны Эрүүгийн хуулийн загвар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг байна.

Гэмт хэргийн шинж, ойлголт, ангилал

Америкийн хууль зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн шинж ойлголтыг тодорхойлох хандлагыг а) формаль б) либерал гэсэн хоёр хандлага давамгайлдаг.

Формаль хандлагын хувьд түгээмэлчлэн томъёолвол эрүүгийн эрх зүйн тодорхой журам зөрчсөн, норматив стандартад халдсан хууль зүйн үр дагавар бүхий гэмт халдлага гэж үздэг. Тухайлбал: профессор П.Таппейний томъёолсноор бол “Гэмт хэрэг гэдэг нь ял ба хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцлийг үгүйсгэж, заавал яллагдах үр дагавар бүхий эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг санаатай зөрчсөн үйлдэл эс үйлдэл” гэж тодорхойлсон¹ бол профессор Дж.Зиглер “Гэмт хэрэг гэдэг нь хууль тогтоомжоор яв цав тодорхойлсон ялын цээрлэл зайлшгүй хүлээх зайлшгүй хүлээх гэмт зан үйл” гэжээ.² Тэгвэл Америкийн профессор Брикс Жексон “Тухайн муж улс өөрсдийн статут хууль, эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр гэмт хэрэг гэж заагаагүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс татгалзах ёстой”³ гэж бичиж байв.

Либераль хандлагын хувьд сүүлийн жилүүдэд нилээд илрэх болсон бөгөөд нийтлэг эрх зүй ба статут хуулийн хоорондох уялдаа, хамааралт хэм хэмжээгээр хориглосон үйлдэл, эс үйлдлийн шууд ба шууд бус хэлбэрүүд гэж үзэх болжээ. Түүнчлэн натуралист болон индивидуалист зарим онолын чиглэл бий. Тухайлбал: “Гэмт хэрэг нь нийгэмд бодит хохирол, гамшиг авч ирдэг тул ямар ч хэргийн хувьд хүнд хөнгөн гэж ялгахгүй хатуу шийтгэх ёстой. Ингэхдээ нийгмээс тусгаарлан гэсгээн цээрлүүлэх ёстой. Гэмт хэрэг үйлдэгчийг нийгмийн зүгээс хүмүүжүүлэх төлөвшүүлэх зорилго тавьж болохгүй, гагцхүү нийгмээс хатуу тусгаарлаж, залхааж цээрлүүлэх ёстой. Гэмт хэрэг хийсэн этгээд өөрөө өөрийгөө ойлгох, ухаарах, төлөвших замаа өөрийн ухамсар, гэмшилээс л олж авах ёстой гэж тайлбарладаг байна. Дээрх хандлага Америкийн эрүүгийн ялын бодлогод гүнзгий тусгагдсан. Иймээс ч баруун Европын судлаачид Америкийн ялын бодлогыг шүүмжлэх нь түгээмэл байдаг.⁴ Ер нь АНУ-д гэмт хэргийг категорчлох замаар гэмт халдлагын илрэх түвшинд өргөн хүрээнд ойлгох хандлага түгээмэл байдгаас үүдэн Америкийн үндсэн хуулийн дагуу Америкийн хууль тогтоомжоор хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө, эрх зүйн дэг журам, аюулгүйн горим, технологи, стандарт зөрчсөн ихэнхи зөрчлийг гэмт халдлагын хүрээнд гэмт үйлдэхүйн илрэл болгон авч үзэх нь олонтаа ажээ.”⁵

¹ Нерсесян А.А. Вопросы наказуемости в уголовном праве ФРГ и США. М., 1992

² Sigler Jay S. Understanding criminal law. Boston. 1981. P 14-15

³ B.Jackson. Criminal Justice in America 1984 p 11

⁴ Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл, шилжилтийн үе. УБ.,2006. 183-184-р тал

⁵ Козочкин И.Д. Уголовное право США: Успехи и проблемы реформирования СПб.Пресс.2007

Зарим муж улсын эрүүгийн хуулинд гэмт хэргийн ойлголтыг тодорхойлсон нь бий. Жишээ нь АНУ-ын Колорода муж улсын эрүүгийн хуулийн 40.4.104-т: “Гэмт хэрэг (crime) гэдэг нь хорих болон торгох ялыг оногдуулахаар журамлан заасан бөгөөд муж улсын хууль тогтоомжийг зөрчсөн зүй бус үйлдэл” бол Нью-Йорк муж улсын эрүүгийн хуулийн 10.1.1-т “Гэмт халдлага (criminal offenses) гэдэг нь хугацаатай хорих ял болон торгох ялыг муж улсын хуулиар тогтоохоор зааснаас гадна хууль тогтоомжоор ирэх олгосны дагуу орон нутгийн засаг захиргааны тогтоол захирамж (ордонанс) ба засгийн газрын байгууллагын баталсан дүрэм журмыг зөрчсөн гэмт зан үйл” гэж заажээ. Тэгвэл мөн хуулийн 10.1.6-д: “Гэмт хэрэг (crime) гэдэг нь мисдиминор ба фелони” гэж тодорхойлжээ.

Гэмт хэргийн категори ангилал төрөл

Америкийн эрүүгийн эрх зүйд гэмт үйлдэхүйг (гэмт халдлага) (criminal offenses) дараахь дөрвөн категорт ангилан авч үздэг нь харьцангуй түгээмэл ажээ. Үүнд:

1. Фелони (*felony*) Нэг жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт үйлдэхүй;
2. Мисдиминор (*misdemeanor*) 15 хоногоос 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт үйлдэхүй;
3. Эрүүгийн зөрчил (*delict*) 15 хоног хүртэл хугацаагаар баривчлах ба хорихоор шийтгэхээр заасан гэмт үйлдэхүй;
4. Замын хөдөлгөөний хэрэг (*minority offences*) замын хөдөлгөөн олон зам тээврийн хууль тогтоомж зөрчсөн хэрэг зөрчил;

Нью-Йорк муж улсын эрүүгийн хуулинд гэмт халдлагын төрөл хүрээг дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний эсрэг гэмт халдлага; (*Хүний амины эсрэг, хүчин, хүнд гэмтэл учруулах*)
- Хүний өмч, эд хөрөнгийн эсрэг гэмт халдлага; (*Бэрглэри, өмчлөх, эзэмшихийн эсрэг гэмт хэрэг, галдан шатаах*)
- Хуурч мэхлэх, залилангийн гэмт халдлага
- Нийтийн засаг захиргааны эсрэг гэмт халдлага
- Нийтийн эрүүл мэнд, ёс суртахууны эсрэг гэмт халдлага;
- Өрх гэр, гэр бүл, хүүхэд, эрх зүйн чадамжгүй этгээдийн эсрэг гэмт халдлага гэх мэт

Түүнчлэн гэмт халдлагын төрлийг эх сурвалжийн шинж, байдлаар нь дээр дурьдсан ерөнхий гэмт хэргүүд ба тусгайлсан гэмт хэргүүд гэж ангилдаг. Тусгайлсан гэмт хэргүүд гэдэгт татварын, экологийн, санхүүгийн үйлдвэрлэлийн технологийн, захиргааны журам зөрчсөн гэмт үйлдлүүд багтах бөгөөд тусгайлсан буюу салбарын чиглэлээр гарсан хуулиудаар зохицуулагдсан байдаг.

Америкийн эрүүгийн эрх зүйд бэрглэри (bergler) гэдэг ойлголтын хүрээнд бусдын орон байр, бусдын амьдарч буй байршил, эзэмшил газар луу шөнийн болон эзгүй үед зөвшөөрөлгүй нэвтрэх, бусдын эд зүйлсийг хулгайлах, ашиглах, завших гэмт хэргийг хамааруулдаг ба Пенсильванийн эрүүгийн хуулийн 3502-р зүйлийн “С”-д зааснаар бол бэрглэри бол фелонийн 1-р түвшинд хамаардаг байна.

АНУ-д ихэнх гэмт хэрэг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй дээрэм эсвэл ашиглан шамшигдуулах гэх мэт буруу үйлдэл байдаг бол цөөн гэмт хэрэг авто ослын дараа зогсож, тусламж үзүүлээгүй эсвэл орлогын татварын тайлангаа гаргаж өгөөгүй гэх мэт эс үйлдэл байна. Зогсоолд давхарлаж зогсох эсвэл амгалан тайван байдал алдагдуулах зэрэг зарим гэмт хэрэгт бага хэмжээний торгууль эсхүл орон нутгийн албадан саатуулах байранд нэг шөнө өнгөрөөх зэрэг шийтгэл оногдуулдаг.¹

Одоогийн байдлаар АНУ-д эрүүгийн үндсэн гэмт хэргүүдийг уламжлалт, эдийн засгийн, зохион байгуулалттай, улс төрийн болон тохиролцсон гэмт хэрэг гэсэн 5 том ангилалд хуваадаг.

1. Уламжлалт гэмт хэрэг: АНУ-д жилд бүртгэгддэг 31 сая гэмт хэргийн ихэнхи нь өмчийн эсрэг гэмт хэрэг байдаг.

2. Эдийн засгийн гэмт хэрэг: 4 том ангилалд хуваадаг.

Хувийн гэмт хэрэг-Мөнгөн ашиг хонжоо олох зорилгоор нэг хүн нөгөө хүний эсрэг хүч хэрэглээгүй гэмт үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь хуурамч чек бичих, орлогын албан татвараа нуух, нийгмийн халамжийн луйвар хийх гэх мэт

Итгэл урвуулан ашиглах гэмт хэрэг-Бизнесийн ажилтнууд буюу төрийн албан хаагчид ажил олгогч эсвэл үйлчлүүлэгчдээ үнэнч байх үүргээ зөрчиж бизнесийн хээл хахууль, эд хөрөнгө ашиглан шамшигдуулах, зардлын хуурамч тооцоо бүрдүүлэх зэрэг үйлдэл байна.

Бизнесийн гэмт хэрэг-Бизнесийн байгууллагын үндсэн зорилго болсон гэмт хэрэг биш, харин түүнтэй холбоотойгоор үйлддэг гэмт хэрэг юм. Буруу, төөрөгдүүлсэн ойлголт өгөх сурталчилгаа, шударга өрсөлдөөний хуулийг зөрчих, байгууллагын орлогын зорилгоор хөрөнгийн тооцоог худал гаргах зэрэг нь бүгд бизнесийн гэмт хэрэг юм.

Луйвар- Бизнесээр халхавчлан цагаан захтнуудын явуулж буй гэмт үйл ажиллагаа юм.

3. Зохион байгуулалттай гэмт хэрэг: Бүлэг этгээд ихэвчлэн ямар нэг шатлалын үндсэн дээр хэн нэгний удирдлага дор үйлдэгддэг гэмт хэрэг юм. Зохион байгуулалттай гэмт хэрэг нь онцгой ашиг орлоготой салбарт чиглэсэн байдаг. Тухайлбал, хууль бусаар хар тамхи наймаалах, мөрийтэй тоглох, биеэ үнэлэх, өндөр хүүтэйгээр мөнгө зээлдүүлэх гэмт хэрэг байна.

4. Улс төрийн гэмт хэрэг: Засгийн эсрэг гэмт хэрэг байдаг. Эх орноосоо урвах,зэвсэгт үймээн дэгдээх, төрийн албан тушаалтны амь насанд халдах, мөн энэ

¹ АНУ-ын Эрх зүйн тогтолцооны товчоон. 118 дахь тал

бүлэгт засгийн газраас хувь хүмүүс, тэрслэгч бүлэг, гадаадын засгийн газар буюу иргэдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг мөн багтаана.

5. Тохиролцсон гэмт хэрэг: Биеэ үнэлэх, мөрийтэй тоглох, хууль бусаар хар тамхи хэрэглэх, харилцан зөвшөөрсөн насанд хүрсэн хүнтэй ёс бус бэлгийн харьцаанд орох гэх мэт хохирогчгүй гэж нэрлэгддэг гэмт хэрэгт гэмт хэрэгтэн ба үйлчлүүлэгч хоёулаа хориглосон үйл ажиллагаа явуулахыг хүссэн байдаг учраас үүнийг тохиролцсон гэмт хэрэг гэдэг.¹

Эрүүгийн хариуцлага хүлээх этгээд (субъект)

АНУ-н хэмжээнд бүхэлд нь авч үзвэл эрүүгийн хариуцлага хүлээх этгээдийн насны шалгуурыг нэгэн мөр нарийвчлан зохицуулаагүй, тухайн хэргийн байдлаас хамаарч өөр өөр тогтоосон байна. Нью-Йорк муж улсын эрүүгийн хуульд зааснаар бол ерөнхий нөхцлийн хувьд 16 насанд хүрээгүй этгээдэд эрүүгийн ял шууд оноож болохгүй боловч онц ноцтойгоор хүний амины хэрэгт 13 наснаас, ердийн хүний амины хэрэгт 14 наснаас эрүүгийн хариуцлага хүлээх нөхцөл бүрдэнэ. Субъектын насны шалгуурын доод хязгаарын хувьд муж улс бүхэнд харилцан адилгүй жишиг тогтсон байх ажээ. Жишээ нь АНУ-ын Оклахома муж улсад зарим хэргийн хувьд 7 наснаас эхэлж тооцдог бол Техас, Нью Тэмпшир муж улсад 15 наснаас, Ореганд 12 наснаас, Иллойнис, Джоржиа мужид 13 наснаас, Колорадад 10 наснаас Айдохо, Калифорния мужид 14 наснаас гэх мэтчилэн харилцан адилгүй тогтоожээ.

Хэрэг хариуцах чадварын шалгуурыг нарийвчлан хуульчлаагүй боловч прецедентын ба жишгийн практикаар зохицуулсан байх ба Макнаменийн (Английн) ба Дурхэмийн гэсэн 2 дүрмээр тогтоож журамладаг ажээ.

Макнамений дүрмээр бол ихэнхи тохиолдолд сэтгэхүйн чадамж, ухамсрын хариуцлага, чадвартай холбон авч үздэг бол

Дурхэмийн дүрмээр сэтгэц-эмгэгийн өвчний шинж, эмнэлгийн шалгуураар голчлон тодорхойлж үздэг.

Америкийн эрүүгийн эрх зүйд хэрэг хариуцах чадварын шалгуурыг тухайн этгээд өөрөө нотлох ба үгүйсгэх боломжтой байх нөхцлийг зөвшөөрсөн байдаг. Хуулийн этгээд буюу корпораци эрүүгийн хариуцлага хүлээх субъект болно.

Ялын төрөл ба ялыг хэрэглэх

АНУ-д эрүүгийн ялын бодлого нь баруун Европ, эх газрын системтэй харьцуулахад зарим ялгаа бий.

Гэмт хэргийн тусгай төрлүүдээс хулгайн хэрэг, түүнд холбогдох бүрэлдэхүүний асуудал нилээд онцлогтой.

¹ АНУ-ын Эрх зүйн тогтолцооны товчоон. 120-121 дэх тал

Хулгайн гэмт хэргийг өргөн хүрээнд авч үздэг. Хулгай нь зөвхөн далд нууц аргаар үйлдэгдэхээр хязгаарлагдахгүй ил буюу эзнийг нь байхад түүнчлэн эзэнд нь мэдэгдэхгүйгээр буюу зөвшөөрөлгүй авах, итгэл эвдэх, төөрөгдүүлэх замаар авах, түүнчлэн энэ нь мөнгө болон эд хөрөнгө төдийгүй төлбөрөөр тооцогдож хэмжигдэж болох (цахилгаан, ус, шатахуун) зүйлс түүнчлэн шууд бус объект (зохиогчийн эрх, оюуны бүтээл)-д халдсан байхыг ойлгоно. Хулгайн гэмт хэргийн каталогт бусдын технологи, бусдын эрхийг эрхийг хулгайлах, завших зэргийг мөн адил хамааруулж ойлгодог.

Гэмт хэрэгт бэлтгэх, завдах болон гэмт хэрэгт хамтран оролцогчийн эрх зүйн байдал, ял хүлээх үндэслэлийг шүүхийн прецедент болон муж улсуудын эрүүгийн хууль тогтоомжоор зохицуулж өгчээ.

Гэмт хэрэгт завдах болон гэмт хэрэгт бэлтгэх хоёрын ялгааг заагласан байх ба эрүүгийн ял хүлээх эсэх нь зарим хэрэг дээр (зохион байгуулалттай гэмт хэрэг) ихэнхдээ шүүхийн прецедентээр тогтоосон байна.

Дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг хаах, тийм нөхцөл гаргуулахгүй байх зорилгоор (three strikes and you are out) “Гурван удаа давтан хэрэг үйлдвээс шахан зайлуулах” гэсэн зарчмыг мөрдлөг болгожээ. Энэ зарчмын дагуу АНУ-ын олон муж улсад гэмт этгээдийг хоёр удаагийн давтан хэрэг буюу гурав дахь удаагаа гэмт хэрэг үйлдэхэд нь хамгийн сүүлийн хэргийн хүнд, хөнгөн эсэхийг үл хамааран бараг бүх тохиолдолд бүх насаар нь хорих ял оноодог болоод байгаа ажээ.¹

Ялын төрлүүдэд

АНУ-ын ялын төрөл	Монгол Улсын ялын төрөл
1. Цаазаар авах	1. Торгох ял
2. Бүх насаар нь хорих	2. Нийтэд тустай ажил хийлгэх ял
3. Хугацаатай хорих	3. Зорчих эрх хязгаарлах ял
4. Хянан харгалзах, (Тэнсэх)	4. Хорих ял
5. Гэрийн хорионд баривчлах	5. Эрх хасах ял
6. Торгох ял зэрэг болно	

Цаазаар авах ялыг АНУ-д 36 муж улс түгээмэл хэрэглэж байгаагийн дээр тухайн муж бүрд 2-5 тохиолдолд Холбооны хэмжээнд нийтэд нь авч үзвэл 60 шахам төрлийн (*давхардсан бус байдлаар*) гэмт хэрэгт хэрэглэдэг ажээ. Ялангуяа 1994 онд “Хүч хэрэглэсэн буюу хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль”

¹ Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл, шилжилтийн үе. УБ., 2006 184-р тал

баталснаас хойш цаазлах ялыг хэрэглэх тохиолдол 30-60 хэрэг хүртэл өсч, уг ялыг хэрэглэх хүрээ нь өргөжин тэлж иржээ.¹

Ихэнхдээ онц ноцтой хүний амины хэрэг, терроризм, хууль бусаар хар тамхи борлуулах, онгоц хулгайлах, барьцаалах, хэрцгийгээр хүчирхийлэх, хүчиндэх, эх орноосоо урвах, тагнуул хийх болон онц ноцтой коррупцийн хэрэг зэрэг цөөнгүй хэрэгт оноодог.

Америкийн зарим муж улсын эрүүгийн хууль тогтоомжид 16 наснаас доош насны этгээдэд цаазаар авах ял оноож байсан түүхэн баримт бий жишээ нь Флорида, Алабама муж улсад эрүүгийн хариуцлага хүлээх насны хязгаарыг тогтоогоогүйгээс болж 10-12 насны этгээдэд цаазаар авах ял хэрэглэж (7 наснаас доошгүй) ирсэн байна. Харин АНУ-ын Дээд Шүүх (Оклахомагийн эсрэг Томпсоны хэрэг) 1989 оны тогтоол гаргаж 13 нас хүрээгүй этгээдэд цаазаар авах ял оноох нь үндсэн хуулийн эсрэг хэрэг гэж зарлажээ.

Цаазаар авах ялыг эмэгтэйчүүдэд хэрэглэх явдлыг хориглоогүй. АНУ цаазаар авах ял хэрэглэдэг ихэнхи муж улсад уг ялыг гүйцэтгэхдээ цахилгаан сандалд суулгах аргыг хэрэглэдэг ба зарим мужид хорт хийгээр хордуулах (Аризон, Невада) буудах, (Юта) дүүжлэх, (Монтана, Вашингтон) аргыг хэрэглэдэг ажээ.² Нийт америкчуудын 78 хувь нь цаазаар авах ял байх ёстой гэж үздэг байна.

Бүх насаар хорих ял нь АНУ-д хэрэглэгддэг хорих ялын нэг төрөл юм. Энэ ялыг голдуу цаазаар авах ялтай дүйцэхүйц тохиолдолд хэрэглэдэг боловч онц хүнд гэмт хэрэг үйлдсэн түүнчлэн фелони гэмт хэрэгт 2 буюу гурван удаагийн шийтгэлтэй этгээдэд хэрэглэнэ. Ялангуяа 3 удаа хэрэг үйлдэж, 3 удаа ял шийтгүүлсэн этгээд дөрөв дэх удаа яллуулах үед бүх насаар нь хорих ял оноодог зарим онцгой тохиолдолд тодорхой нөхцөл байдалд цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн хувьд ялыг орлуулан солих замаар хэрэглэдэг.

Хугацаатай хорих ялын хувьд түүний нөхцөл, хугацаа, дэглэмийг эрүүгийн хууль тогтоомжоор нэг мөр нарийвчлан тогтоодоггүй бөгөөд харин ихэнхдээ шүүхийн прецедентын жишигт нийцүүлэн шүүх, тангарагтны шүүх болон ял эдлүүлэх байгууллага өөрсдөө тодорхойлно. Өөрөөр хэлбэл хугацаатай хорих ялын доод хугацаа ба дээд хэмжээний хувьд дундаж ерөнхий нөхцөл гэж байхгүй, ихэнхи тохиолдолд шүүх тодорхой бус таслан шийдвэрлэх тогтоол гаргадаг байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

1. Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагааг ихэнхдээ ял тохиролцох, гэм бурууг хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэгдсэн түргэвчилсэн процесс болгон уян

¹ В.Н.Додоно. Сравнительное уголовное право. Общая часть. М., 2009 с.278

² А.А. Малиновский Уголовное право зарубежных государств. М., 1998 27-р тал

хатан нөхцөлөөр явуулдаг нь хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, хүний эрх, нэр төрийг хамгаалах, хохирол, үр дагаврыг богино хугацаанд арилгуулах зэрэг сайн талтай ба эерэг, нааштай олон хүчин зүйлийг агуулдаг байна. Зарим тохиолдолд хэргийг бүх талаас нь бүрэн бодитойгоор, үнэн зөв шалган шийдвэрлэх зарчимтай зөрчилддөг ба нотлох ажиллагааг бүрэн хангахад шүүхийн оролцоо хязгаарлагдмал, мэтгэлцэх талуудын субъектив хүсэл зориг хэргийн хувь заяаг тодорхойлдог зэрэг нь сөрөг хүчин зүйл болдгийг үгүйсгэх аргагүй. Харин эрүүгийн процессын албадлагын арга хэмжээнд хүний эрхийг хангуулах, шүүхийн мэтгэлцээний сонгодог хэв шинжийг тогтвортой хадгалсаар ирсэн нь үнэ цэнэтэй бөгөөд олон улс оронд үлгэр загвар болж, тархан дэлгэрсээр байна.

2. Гэм бурууг хүлээн зөвшөөрч, ялын тохиролцоог хийхийн өмнө тухайн яллагдаж буй этгээд зөвхөн өөрийн ухамсар, өөрийн сайн дурын ухаалаг шийдвэрт үндэслэх ба прокурор өмгөөлөгчийн зүгээс ямар нэгэн байдлаар айлган сүрдүүлэх барьцаанд оруулах дарамт шахалт үзүүлэхийг хориглосон байдаг байна. Сүүлийн үед хийгдсэн нэгэн судалгаагаар Америкийн хэмжээнд нийт гэмт хэргийн 95 хувь нь ял тохиролцох үндсэн дээр шийдэгдсэн байдаг бол ердөө 5 хувь нь шүүх хуралдааны дүнд шийдвэрлэгдсэн болох нь тогтоогджээ.